

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

## Ангилалтын код 13.020.50

<b>Эко тэмдэг ба мэдэгдэл – Ерөнхий зарчим</b>	<b>MNS ISO 14020: 2004</b>
<b>Environmental labels and declarations – General principles</b>	(MNS ISO 14020: 1999-ийн оронд)

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2004 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2004 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандарт зөвлөмжийн шинж чанартай.

### 1 Хамрах хүрээ

Олон улсын энэхүү стандарт нь эко тэмдэг, мэдэгдлийг боловсруулах ба хэрэглэхэд чиглүүлэх зарчмуудыг тогтооно. ISO 14020 цувралын бусад стандартуудыг олон улсын энэхүү стандарттай хамт хэрэглэвэл зохино.

Олон улсын энэ стандартыг баталгаажуулалт, бүртгэлийн зориулалтад техникийн нөхцөл байдлаар хэрэглэхэд зориулаагүй болно.

**ТАЙЛБАР:** ISO 14020 цувралын бусад олон улсын стандартууд нь энэхүү олон улсын стандартын 4-р бүлэгт заасан зарчимтай нийцэж байвал зохино. Одоогийн байдлаар ISO 14020 цувралд ISO 14021, ISO 14024 ба ISO/TR 14025 (номзүйг үзнэ үү) стандартууд хамаарна.

### 2 Нэр томьёо ба тодорхойлолт

Энэхүү стандартад дараахь нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

#### 2.1

##### **эко тэмдэг**

##### **байгаль орчны мэдэгдэл**

Бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчны асуудлыг зааж буй шаардлага.

**ТАЙЛБАР:** Эко тэмдэг ба мэдэгдэл нь томьёолол, тэмдэг, график хэлбэрээр бүтээгдэхүүн болон түүний сав баглаа боодол дээр эсвэл бүтээгдэхүүний талаархи ном, техникийн сэтгүүл, сурталчилгаа гэх мэт бусад хэлбэрээр байж болно.

#### 2.2

##### **амьдралын мөчлөг**

Түүхий эд эсхүл байгалийн нөөц баялгийг худалдан авч, боловсруулалтаас эхлэн эцсийн хаягдал хүртэлх бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үе шатны дэс дараалал, эсвэл шүтэлцээт холбоо

[ИСО 14040:1997]

**ТАЙЛБАР:** “Бүтээгдэхүүн” нь бараа эсвэл үйлчилгээг хамаарна.

### **2.3**

#### **байгаль орчны асуудал**

байгаль орчинтой харилцан үйлчилж байгаа, тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний эсхүл байгууллагын үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг

## **3 Эко тэмдэг болон мэдэгдлийн зорилго**

Эко тэмдгийн ба мэдэгдлийн гол зорилго бол бүтээгдэхүүн, үйлчилгээний байгаль орчны асуудлыг төөрөгдөлд орохооргүй, баталгаатай, үнэн зөв мэдээлснээр тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ нь экологид бага хохирол учруулах, үүний үр дүнд зах зээлийн зорилгод чиглэсэн байгаль орчныг байнга сайжруулах боломжийг дэмжих явдал мөн.

## **4 Ерөнхий зарчим**

### **4.1 Ерөнхий зүйл**

Эко тэмдэг ба мэдэгдэлд 4.2-оос 4.10-р зүйлд заасан бүх зарчмуудыг хэрэглэх боломжтой.

Хэрэв ISO 14020 цувралын бусад олон улсын стандартуудад ISO 14020 стандартад зааснаас илүү онцгой шаардлагуудыг тусгасан бол тэдгээрийг мөрдөнө.

### **4.2 Зарчим 1**

#### **4.2.1 Үндсэн асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдэл нь үнэн зөв, нотолгоотой, тухайн асуудалд холбогдолтой төөрөгдүүлэхээргүй байвал зохино.

#### **4.2.2 Онцлог асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдлийн үр ашиг, өгөөж нь бүтээгдэхүүн ба үйлчилгээний байгаль орчны асуудлын талаар хэр зэрэг бодитой, олон талын мэдээллийг агуулсан цар хэмжээнээс хамаарна. Эко тэмдэг ба мэдэгдэл нь бүтээгдэхүүн болон үйлчилгээний байгаль орчны асуудлын тухай үнэн зөв мэдээллийг агуулна. Эко тэмдэг ба мэдэгдлийн бодитой байдал, техникийн үндэслэл нь баталгаатай байх шаардлагатай. Эко тэмдэг ба мэдэгдэл нь тухайн асуудалтай холбогдолтой мэдээллийг агуулна. Эко тэмдэг ба мэдэгдэл нь зөвхөн бүтээгдэхүүн ба үйлчилгээтэй холбогдол бүхий байгалийн баялагийг гарган авах, үйлдвэрлэх, түгээх, хэрэглэх, хаях зэрэг үндсэн үйл ажиллагаанд хамаарах байгаль орчны асуудалд чиглэгдэнэ. Эко тэмдэг ба мэдэгдлийн үндэслэлийг тодорхой хугацаагаар хянаж, дүн шинжилгээ хийхдээ шинэ дэвшилтэт санааг тусгах хэрэгтэй. Мэдээлэл нь шинэ дэвшилтийн ололт амжилт бүрийг өргөн агуулсан байна.

Эко тэмдэг ба мэдэгдэл нь ойлгоход хялбар, түүнчлэн бүтээгдэхүүн буюу үйлчилгээг хэрэглэгчийг төөрөгдүүлж, хуурахгүй байвал зохино.

### **4.3 Зарчим 2**

#### **4.3.1 Үндсэн асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдлийн журам, шаардлагуудыг олон улсын худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэхэд нөлөөлөхөөр боловсруулж, батлаж, хэрэглэж болохгүй.

#### **4.3.2 Онцлог асуудал**

Дээрх зарчмуудын талаархи журмыг гаргахын тулд Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан заалтууд ба зөвлөмжөөс хэрэглэх боломжтойг тусгах нь зүйтэй.

### **4.4 Зарчим 3**

#### **4.4.1 Үндсэн асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдэл нь шаардлагыг биелүүлэхэд хангалттай үндэслэлтэй, ойлгомжтой, үнэн зөв, үр ашигтай үр дүн гаргахуйц шинжлэх ухааны аргачлалд үндэслэсэн байвал зохино.

#### **4.4.2 Онцлог асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдлийн талаархи мэдээллийг хүлээн авах ба үнэлэхдээ шинжлэх ухааны буюу мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрч, өргөнөөр ашиглаж байгаа эсвэл шинжлэх ухаан үндэслэлээр эрх нь хамгаалагдсан аргыг хэрэглэнэ. Эдгээр арга нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартууд (олон улсын, бүс нутгийн болон үндэсний стандартууд)-ыг эсвэл реер үнэлгээ хийлгэсэн стандартууд ба аргуудыг мөн адил хянаж байдаг үйлдвэрлэл, худалдааны аргуудыг мөрдөнө. Эдгээр аргууд нь шаардлагад нийцсэн, шаардлагыг үнэн зөв байлгахын тулд холбогдох хэрэгцээт мэдээллийг агуулсан байна.

### **4.5 Зарчим 4**

#### **4.5.1 Үндсэн асуудал**

Журам, аргачлал болон аливаа шалгуур үзүүлэлтүүдтэй холбогдолтой мэдээллийг эко тэмдэг ба мэдэгдлийг хэрэглэх боломжтой сонирхогч талуудын шаардлагыг хангахын тулд ашиглана.

#### **4.5.2 Онцлог асуудал**

Мэдээлэл нь үндсэн зарчмууд, үүрэг хариуцлагыг өөрөө хариуцах наад захын нөхцлүүдийг багтаана. Мэдээлэл нь худалдан авагч болон бусад сонирхогч талуудад эко тэмдэг ба мэдэгдлийн шинжлэх ухааны үндэслэлийн зарчим, ISO 14020-ын цуврал стандартуудтай хэрхэн нийцэж байгааг үнэлж харьцуулах хангалттай, ойлгомжтой байх шаардлагатай.

Түүнчлэн энэ мэдээлэл нь эко тэмдэг ба мэдэгдлийг өөрөө мэдүүлсэн байгаль орчны шаардлага уу эсвэл бие даасан баталгаан дээр үндэслэсэн үү гэдгийг тодорхой заана.

Энэ мэдээллийг олж авах арга зам нь зах зээл дэх аливаа бүтээгдэхүүн ба үйлчилгээг хэрэглэгч тодорхой мэддэг байвал зохино. Мөн мэдээллийг авахдаа 4.10-р зүйлд дурдсан янз бүрийн аргыг хэрэглэж болно.

Эдгээр нь бизнесийн нууц мэдээлэл, оюуны өмчийг хамгаалсан эрх эсвэл адил төстэй хууль эрхийн хязгаарлалт зэрэг онцлог мэдээллүүдээр хязгаарлагдаж болно.

## **4.6 Зарчим 5**

### **4.6.1 Үндсэн зүйл**

Эко тэмдэг ба мэдэгдлийг боловсруулахдаа бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн бүхий л холбогдолтой асуудлуудыг анхаарч тусгах хэрэгтэй.

### **4.6.2 Онцлог асуудал**

Бүтээгдэхүүн ба үйлчилгээний амьдралын мөчлөг нь түүхий эд материалыг боловсруулах, түгээх буюу байгалийн баялагийг гарган авахаас эхлэн эцсийн хаягдал хүртэл үргэлжлэх үйл ажиллагааг хамаарна. Бүтээгдэхүүн ба үйлчилгээний амьдралын мөчлөгийг авч үзэхдээ эко тэмдэг ба мэдэгдлийг хэрэгжүүлж байгаа этгээдэд байгаль орчинд нөлөөлөх хүчин зүйлүүдийг тусгахыг анхааруулна.

Түүнчлэн энэ нь эко тэмдэг ба мэдэгдлийн холбогдолтой шинж чанарууд, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох буюу байгаль орчны шаардлагын чухал ач холбогдлыг тодорхойлоход хэрэгтэй. Амьдралын мөчлөгийн хамрах хүрээ нь эко тэмдэг ба мэдэгдлийн төрөл, шаардлагын бодит байдал, бүтээгдэхүүний ангилал зэргээс хамааран янз бүр байж болно.

Энэ нь амьдралын мөчлөгийн үнэлгээ заавал байна гэсэн ойлголт биш.

## **4.7 Зарчим 6**

### **4.7.1 Үндсэн асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдэл нь байгаль орчны үзүүлэлтийг дээшлүүлэх боломжийг бүрдүүлж байгаа шинэ санаа, дэвшилд саад учруулахгүй байвал зохино.

### **4.7.2 Онцлог асуудал**

Шаардлагууд нь зохион бүтээлтийн болон дүрслэлийн шинж чанараасаа илүү үзүүлэлтийн нэр томъёогоор илэрхийлэгдсэн байх хэрэгтэй. Энэ хандлага нь техникийн болон бусад шинэ дэвшилтэт санааг нэвтрүүлэх дээд зэргийн боломж олгоно.

Технологийн урьдчилан тогтсон зохион бүтээлт эсвэл таамаглаж буй саналыг хэрэгсэхгүй няцааж болно. Учир нь бүтээгдэхүүн ба үйлчилгээнд гарч болох хориг хязгаарлалтын өсөлт нь байгаль орчны шалгуур үзүүлэлтэд тохироход нөлөөлөхгүй байх эсвэл байгаль орчны чухал ач холбогдолтой өсөлтийг удирдан чиглүүлж байж болно.

## **4.8 Зарчим 7**

### **4.8.1 Үндсэн асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдэлтэй холбогдолтой захиргааны аливаа шаардлага буюу мэдээллийн эрэлт хүсэлт нь тэмдэг ба мэдэгдлийн талаархи стандарт, шалгуур үзүүлэлтүүдтэй тохирч байгааг тогтоохын тулд хязгаарлагдмал байна.

#### **4.8.2 Онцлог асуудал**

Хэмжээнээсээ үл хамааран бүх байгууллагууд эко тэмдэг ба мэдэгдлийг хэрэглэхдээ адил тэгш эдэлнэ. Байгууллагуудыг энэ үйл ажиллагаанд оролцоход гадны хүчин зүйлүүд болон журамд тусгасан хүндрэлтэй асуудлууд, шаардлагагүй мэдээлэл, захиргааны шаардлага зэрэг нь саад болохгүй байвал зохино.

### **4.9 Зарчим 8**

#### **4.9.1 Үндсэн асуудал**

Эко тэмдэг ба мэдэгдлийг боловсруулах үйл явц нь нээлттэй бөгөөд сонирхогч талуудтай зөвлөлдөх боломжтой байна. Үйл явцын туршид зөвшөлцөлд хүрэх оролдлогыг хийх хэрэгтэй.

#### **4.9.2 Онцлог асуудал**

Стандарт ба шалгуур үзүүлэлтийг боловсруулах үйл ажиллагаа нь сонирхогч талуудад нээлттэй. Сонирхогч талуудыг оролцохыг урих бөгөөд зарласан хугацаанд оролцох ёстой. Талууд шууд эсвэл бичгээр буюу цахилгаан мэдээлэл гэх мэт бусад хэрэгслээр хэрхэн оролцох байдлаа сонгоно.

Санал өгсөн талуудад тохирсон, тодорхой хариу өгвөл зохино. ISO 14021 стандартын дагуу боловсруулсан өөрийн зарласан байгаль орчны мэдүүлгийг олон улсын энэхүү стандартыг боловсруулах явцад хийсэнтэй адил хэлэлцүүлсэн байна.

### **4.10 Зарчим 9**

#### **4.10.1 Үндсэн асуудал**

Эко тэмдэг буюу мэдэгдэлтэй холбоотой бүтээгдэхүүн болон үйлчилгээний байгаль орчны асуудлын талаарх мэдээллийг эко тэмдэг ба мэдэгдлийг гаргаж байгаа талаас хэрэглэгч авах боломжтой байна.

#### **4.10.2 Онцлог асуудал**

Ихэнхдээ эко тэмдэг ба мэдээллийн үр ашиг нь хэрэглэгч худалдан авах шийдвэр гаргахдаа хүрээлэн буй орчны чиг баримтлалыг харгалзан сонголт хийх, түүнийхээ үүрэг хариуцлагыг хүлээх болон бүтээгдэхүүн ба үйлчилгээг сонгон авахад нөлөөлөх зэргээс хамаарна. Энэ нь байгаль орчны чиг асуудлын тухай мэдээллээр хангагдсан худалдан авагчийг хүлээн зөвшөөрөх ба ойлголцох түвшинтэй холбоотой.

Иймд эко тэмдэг ба мэдэгдлийг хэрэглэж байгаа талууд нь өөрийн худалдан авагчдад эко тэмдэг, нэр томъёо, шаардлагын учир холбогдлын талаархи ойлголтыг өгөх мэдээллээр хангахын тулд үүрэг хариуцлага хүлээнэ. Энэ зорилгоор сурталчилгаа, тайлбар самбар, утасны үнэгүй дугаар, сургалтын хөтөлбөр зэрэг төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглаж болно. Эдгээр мэдээлэл нь байгаль орчинд тавигдах шаардлагад тохирсон хангалттай байх шаардлагатай.

**ТӨГСӨВ.**

**Ном зүй**

1. MNS ISO 14021: 2001, Эко тэмдэг ба мэдэгдэл- Өөрийн зарласан байгаль орчны мэдүүлэг (Эко тэмдэг хэрэглэх II загвар)
2. MNS ISO 14024:1999, Эко тэмдэг ба мэдэгдэл – Байгаль орчныг тэмдэглэх 1-р загвар - Зарчим ба журам
3. MNS ISO/TR 14025:2001, Эко тэмдэг ба мэдэгдэл. Байгаль орчны мэдэгдлийн III загвар
4. MNS ISO 14040: 2001, Байгаль орчны удирдлага. Амьдралын мөчлөгийн үнэлгээ. Зарчим ба хамрах хүрээ
5. ISO/ IEC Guide 2, Стандартчилал, холбогдох үйл ажиллагаа- Ерөнхий тайлбар толь
6. ISO/ IEC Guide 59, Стандартчиллын практик ажиллагааны дүрэм